

Улирлын урьдчилсан төлөв

Нэг. ТАНЫ АНХААРАЛД

Ус Цаг Уур, Орчны Судалгаа, Мэдээллийн Хүрээлэн (УЦУОСМХ)-ийн Хиймэл оюун ухаан, Тоон загварчлал, Судалгааны Хэлтэс (ХОУТЗСХ)-ээс 2025 оны 12 дугаар сараас 2026 оны 02 дугаар саруудын цаг агаарын урьдчилсан төлөвийг тооцоолон танд хүргэж байна.

Урьдчилсан төлөвийг [Цаг.araap \(weather.gov.mn\)](http://Цаг.araap.weather.gov.mn) цахим хуудсанд сар бүрийн 28-нд шинэчлэн гаргадаг тул хэрэглэгч та бүхэн тухай бүрд нь шинэчилсэн мэдээг ашиглаж байна уу.

Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-аас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэгт 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг.

Улирлын төлөвийн талаар лавлах шаардлагатай бол УЦУОСМХ-ийн 11–326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн ХОУТЗСХ-ээс тодруулах боломжтой.

Хоёр. ТОЙМ

2.1 12–02 дугаар саруудын уур амьсгал


Сарын дундаж агаарын температур арванхоёрдугаар сард Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Өвөрхангайн баруун хойд, Төвийн зүүн хойд хэсгээр -24...-30°C, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр -10...-16°C, бусад нутгаар -16...-24°C, нэгдүгээр сард Баян–Өлгийн нутаг, Увсын хойд болон өмнөд, Завхан, Хөвсгөл, Сэлэнгийн ихэнх, Архангайн баруун, Төвийн зүүн хойд хэсгээр -26...-32°C, Говь–Алтай, Баянхонгор, Дорноговийн өмнөд, Өмнөговийн ихэнх нутгаар -12...-18°C, бусад нутгаар -18...-26°C, хоёрдугаар сард Баян–Өлгий, Увс, Завхан, Хөвсгөлийн ихэнх, Архангайн баруун, Сэлэнгийн хойд, Төвийн зүүн хойд хэсгээр -22...-28°C, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговийн өмнөд хэсэг болон Өмнөговийн ихэнх нутгаар -8...-14°C, бусад нутгаар -14...-22°C тус тус хүйтэн байдаг байна.

Хур тунадасны хувьд арванхоёрдугаар сард Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон Дорнодын тал нутгаар 2–8 мм, бусад нутгаар 0–2 мм, нэгдүгээр сард Хангайн нурууны төгсгөл, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Дорнодын тал нутгаар 2–4 мм, бусад нутгаар 0–2 мм, хоёрдугаар сард Завханы зүүн, Архангайн өмнөд, Хөвсгөлийн баруун хойд, Сэлэнгийн зүүн, Төв аймгийн зүүн хойд хэсгээр 2–4 мм, бусад нутгаар 0–2 мм ордог байна.

Гурав. 2025 ОНЫ 12 ДУГААР САРААС 2026 ОНЫ 02 ДУГААР САРУУДЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

3.1 2025 оны 12 дугаар сараас 2026 оны 02 дугаар саруудын цаг агаарын урьдчилсан төлөв


Арванхоёрдугаар сард. Агаарын дундаж температур Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнодын нутаг, Архангайн ихэнх, Сүхбаатарын хойд хэсгээр ОЖД–аас хүйтэн, Ховд, Говь–Алтай, Баянхонгорын өмнөд хэсэг, Өмнөговийн нутгаар ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 1**).



Зураг 1. 2025 оны 12 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

[Х–агаарын температур ОЖД–аас хүйтэн, Н–агаарын температур ОЖД–ын орчим, Д–агаарын температур ОЖД–аас дулаан]


Сарын нийлбэр хур тунадас Булган, Сэлэнгэ, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорнодын нутаг, Хөвсгөлийн зүүн, Сүхбаатарын хойд хэсгээр ОЖД–аас ахиу, Баян–Өлгийн нутаг, Ховд, Говь–Алтай, Баянхонгорын өмнөд хэсгээр ОЖД–аас бага, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 2**).



Зураг 2. 2025 оны 12 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[Б–хур тунадас ОЖД–аас бага, Н–хур тунадас ОЖД-ийн орчим, И–хур тунадас ОЖД–аас ахиу]


Нэгдүгээр сард. Агаарын дундаж температур Говь–Алтай, Баянхонгорын өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 3**).



Зураг 3. 2026 оны 1 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

[Д–агаарын температур ОЖД–аас дулаан, Н–агаарын температур ОЖД–ын орчим]


Нийлбэр хур тунадас Увс, Завхан, Хөвсгөл, Архангай, Булганы нутаг, Ховд, Говь–Алтай, Баянхонгорын хойд, Өвөрхангайн баруун хойд, Сэлэнгэ, Төвийн баруун хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 4**).



Зураг 4. 2026 оны 1 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[И–хур тунадас ОЖД–аас ахиу, Н–хур тунадас ОЖД–ийн орчим]


Хоёрдугаар сард. Агаарын дундаж температур Завхан, Хэнтийн ихэнх, Увс, Төв аймгийн зүүн, Хөвсгөл, Архангайн баруун, Баянхонгор, Дорнодын хойд хэсгээр ОЖД–аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 5**).



Зураг 5. 2026 оны 2 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

[X–агаарын температур ОЖД–аас хүйтэн, H–агаарын температур ОЖД–ын орчим]

Нийлбэр хур тунадас Дорноговийн нутаг, Өмнөговийн зүүн, Сүхбаатарын баруун өмнөд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 6**).



Зураг 6. 2026 оны 2 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[И–хур тунадас ОЖД–аас ахиу, Н–хур тунадас ОЖД–ийн орчим]

3.2 Зөвлөмж

Өвлийн саруудад нутгийн хойд хэсгээр олон жилийн дунджаас хүйтэн, харин нутгийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

Тухайлбал: 2025 оны 12 дугаар сард төв болон зүүн аймгуудын нутгаар ОЖД–аас хүйтэн, нутгийн баруун өмнөд хэсгээр ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх бол 2026 оны 1 дүгээр сард ихэнх нутгаар ОЖД–ийн орчим байх хэдий ч Говь–Алтай, Баянхонгорын өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр ОЖД–аас дулаан, 2 дугаар сард Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг бүс нутгуудаар ОЖД–аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

Хур тунадасны хувьд 12 дугаар сард төв болон зүүн аймгуудын нутгаар ОЖД–аас ахиу, нутгийн баруун өмнөд хэсгээр ОЖД–аас бага, 1 дүгээр сард баруун аймгуудын нутгийн хойд болон зүүн, төвийн аймгуудын нутгийн

баруун хэсгээр ОЖД–аас ахиу, 2 дугаар сард нутгийн зүүн өмнөд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.